

## *Боловсролын Зээлийн Сангаас сургалтын төлбөр авах оюутны бүрдүүлэх материал*

Дараах суралцагчид сургалтын төлбөр олгоно.

- Бүтэн өнчин
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутан
- Эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй
- Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн суралцагч
- 1 гэр бүлээс 3 оюутан зэрэг суралцаж буй бол 1 нь хамрагдана.

**Бүрдүүлэх материал:**

1. Суралцах эрхийн бичиг /УБ-аас элсэгч бол “Суралцах гэрээ байгуулах эрхийн бичиг”/
  2. Бүрэн дунд боловсролын гэрчилгээний хуулбар
  3. Батламжийн хуулбар /ЭЕШ-ын оноо/
  4. Оюутны төрсний гэрчилгээний хуулбар
  5. Оюутны өөрийн болон эцэг, эхийн иргэний үнэмлэхийн хуулбар /1 хуудасд багтаах/
  6. Баг /улаанбаатарт бол хорооны/ -ийн тодорхойлолт
    - 7.А.Бүтэн өнчин /эцэг, эхийн нас баралтын гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбарыг 1 хуудасд багтаах/
    - 7.Б.Оюутан хөгжлийн бэрхшээлтэй, 50 хувиас доошгүй хөдөлмөрийн чадвар алдалттай болохыг тогтоосон **хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоосон акт**
    - 7.В.Эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бол тус бүр 50 хувиас доошгүй хөдөлмөрийн чадвар алдалттай болохыг тогтоосон **хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоосон акт**
    - 7.Г.Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан өрхийн гишүүнтэй бол 70 хувиас доошгүй хөдөлмөрийн чадвар алдалттай буюу хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан болохыг тогтоосон **хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоосон акт**
  8. Өргөдөл /оюутны өөрийн болон эцэг эхийн /
  9. Төлбөрийн нэхэмжлэх /санхүүгээс авах/
  10. Сонгосон кредитийн баталгаажуулсан жагсаалт
  11. Өмнөх улирлын /2018-2019 оны намрын/ баталгаажуулсан Үнэлгээний голч дүн
- Эдгээр материалуудыг бүрдүүлээд Сургалтын албанд хураалгана уу*